



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2022 оны 4 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар
ХОТ

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн,
удирдамж батлах тухай

1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 31.2 дахь хэсэгт заасны дагуу хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ахлагч:

-Тагнуулын ерөнхий газрын дарга,
хошууч генерал П.Одонбаатар

Гишүүд:

-Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн
Г.Нарантуяа;

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн
бичгийн дарга Ц.Эрдэмбилэг;

-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны
Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр;

-Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн
нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн;

-Монголбанкны Удирдлага, төлөвлөлтийн
газрын Аюулгүй байдлын албаны дарга
Г.Дөлгөөн (зөвшилцсөнөөр);

-Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл;

-Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Кибер аюулгүй байдлын бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Э.Насанбат;

-Харилцаа холбооны зохицуулах хорооны
Интернэтийн сүлжээ, үйлчилгээний хэлтсийн
дарга Т.Батболд;

-Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк,
санхүүгийн эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
Г.Байгал (зөвшилцсөнөөр);

-Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын ахлах зөвлөх А.Баянмөнх (зөвшилцсөнөөр);

-Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Онон;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Ууганбаяр;

-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Сургалт, гишүүнчлэлийн хэлтсийн дарга Б.Долоонжин (тохиролцсоноор);

-Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Гишүүнчлэлийн газрын дарга Ц.Магнайбаатар (тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга:

-Тагнуулын ерөнхий газрын тасгийн дарга
Ч.Чимидрэгзэн.


2. Биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3. Биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагааг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор багтаан зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (П.Одонбаатар)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



Ерөнхий сайдын 2022 оны 55 дугаар
захирамжийн хавсралт

БИЕИЙН ДАВХЦАХГҮЙ ӨГӨГДӨЛ (ГАРЫН ХУРУУНЫ ХЭЭ)-ИЙГ УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 31.1-д заасан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавихад энэхүү удирдамжийг баримтална.

1.2.Мэдээлэл хариуцагчийн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөс өмнө хуулиар зөвшөөрснөөс бусад аргаар цуглуулсан, хадгалсан (олж авсан, бүрдүүлсэн, бүртгэсэн зэрэг) биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийн мэдээллийг (цаашид “мэдээлэл” гэх) устгана.

1.3.Мэдээлэл хариуцагч нь биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг цуглуулахад үндэслэл болгосон, дотооддоо батлан мөрдөж байгаа журам болон бусад эрх зүйн актыг хүчингүй болгуулах арга хэмжээг авна.

Хоёр.Хамрах хүрээ

2.1.Биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагаанд төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбогдсон мэдээлэл хариуцагчийг хамруулна.

2.2.Ажилтны цагийг гарын хурууны хээгээр бүртгэдэг, эсхүл бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор гарын хурууны хээг ашигладаг нийтийн болон хувийн эрх зүйн этгээдийг энэ удирдамжийн 2.1-д заасан үйл ажиллагаанд хамруулна.

Гурав.Хэрэгжүүлэх хугацаа

3.1.Ажлын хэсэг мэдээлэл хариуцагчийн цуглуулсан, хадгалсан гарын хурууны хээний мэдээллийн санг устгах үйл ажиллагааг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор хэрэгжүүлнэ.

Дөрөв.Ажлын хэсгийн чиг үүрэг, үйл ажиллагаа

4.1.Биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсэг дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах мэдээлэл хариуцагчийг тодорхойлж, жагсаалт гаргах;